

Байгалийн ухааны багш нарын мэргэжлийн сургалт зохион байгуулагдлаа.

Хими, физик, газарзүйн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг **2025 оны 03 дугаар сарын 29-ны өдөр** Хан-Уул цогцолбор сургууль дээр зохион байгууллаа. Сургалтад Химийн 19 багш, физикийн 15 багш, 13 газарзүйн багш хамрагдсан ба сургалтыг Улаанбаатар хотын “**Орчлон**” **сургуулийн** физикийн багш, Улсын физикийн олимпиадын хошой мөнгө, хүрэл медальт, олон улсын Кембрижийн хөтөлбөрийг 5 дахь жилдээ хэрэгжүүлж **О.Төгөлдөр**, Орчлон сургуулийн газарзүйн багш, кембрижийн checkpoint, igcse, as Level хөтөлбөрийн багш **Э.Болдбаатар**, Орчлон сургуулийн химийн багш, Кембрижийн хөтөлбөрийн багш, химийн улсын олимпиадын мөнгөн медальтай, олон улсын химийн олимпиадын мөнгө, хүрэл медальт багш **С.Сувданчимэг** нар удирдан дараах агуулгын хүрээнд сургалтыг зохион байгууллаа.

Физик. Эргэлтийн кинематик тэгшитгэлүүд, Эргэлтийн динамик тэгшитгэлүүд, бодлого бодох зөвлөмж, Эргэх хөдөлгөөний хадгалагдах хуулиуд, Хэлбэлзэл, физик дүүжин.

Хими. Органик механизмд үндэслэн функциональ бүлгийг заах, Тэнцвэр ба хурдны онолын ялгаа, Тэнцвэрийн хүндэрсэн тооцоонууд, Электрхимийн онол ба туршилт,

Газарзүйн хичээл. Багш мэргэжлийн ирээдүйн чиг хандлага, дадлага ажил, ОУ-н хөтөлбөрийн Газарзүйн хичээлийг зааж буй туршлага, ОУ-н хөтөлбөр болон үндэсний хөтөлбөрийн газарзүйн хичээлийн үнэлгээг харьцуулах нь, ЭШ-н агуулгыг багцалж заах нь, Дадлага ажил /блюпринтийн дагуу тест хийх/





Мэдээлэл бэлтгэсэн Ахлах арга зүйч Ц.Балжинням